

**ДИПЛОМАТ, АЛБАН БОЛОН ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД
ПАСПОРТ БҮХИЙ ИРГЭДИЙГ ВИЗЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ИЗРАИЛЬ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Израиль Улсын Засгийн газар /цаашид
“Хэлэлцэн тохирогч Талууд” гэнэ/

хоёр орны хооронд тогтсон найрсаг харилцааг улам бүр хөгжүүлэхийг
эрмэлзэн,

хоёр орны хооронд иргэд харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

Нэгдүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын хүчин төгөлдөр дипломат, албан паспорт
бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 30 хүртэл хоногийн
хугацаанд түүний визгүйгээр зорчих буюу дамжин өнгөрч болно.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын хүчин төгөлдөр дипломат, албан паспорт
бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 30 хоногоос дээш
хугацаагаар зорчих бол урьдчилан виз авна.

3. Энэ зүйлийн хоёрдугаарт заасан визийг харилцан хураамжгүйгээр олгоно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт байгаа Хэлэлцэн тохирогч
нөгөө Талын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт ажилладаг
Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат, албан паспорт бүхий иргэд, тэдний гэр
бүлийн гишүүд томилолтын хугацаандаа тухайн Талын нутагт визгүйгээр зорчино.

Гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын хүчин төгөлдөр үндэсний энгийн гадаад
паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 30 хүртэл
хоногийн хугацаанд визгүйгээр зорчих буюу дамжин өнгөрч болно.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын хүчин төгөлдөр үндэсний энгийн гадаад
паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт 30 хоногоос илүү
хугацаагаар зорчих бол урьдчилан виз авна.

3. Энэ зүйлийн хоёрдугаарт заасан визийг олгохдоо Хэлэлцэн тохирогч
Талуудын дотоод хууль, журмын дагуу хураамж авна.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Тал энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд дурдсан
Хэлэлцэн тохирогч нөгөө Талын тааламжгүй гэж үзсэн иргэнийг өөрийн нутаг
дэвсгэртээ оруулахаас татгалзах болон байх хугацааг нь богиносгох эрхтэй.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчихдоо түүний олон улсын зорчигчдод нээлттэй боомтоор нэвтэрнэ.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал өөрийн иргэнийг буцаж ирэх үед нь ямар нэгэн саадгүйгээр нутаг дэвсгэртээ оруулна.

Долдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах үүднээс Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийм арга хэмжээ авсан тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэж байна.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий байгууллагууд Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болохоос гуч (30) хоногийн өмнө хүчин төгөлдөр паспортуудын загварыг дипломат шугамаар солилцоно.

Есдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт аливаа нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл түүнийг хянан үзэх журам нь энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох журамтай нэгэн адил байна.

Аравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг Хэлэлцэн тохирогч Тал тус бүрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу батлах эсхүл соёрхон батлах бөгөөд тийнхүү баталсан эсхүл соёрхон баталсан тухай сүүлчийн дипломат нотыг хүлээн авсан өдрөөс Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

Арван нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийг тодорхой бус хугацаагаар байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцээрийг цуцлах тухай хүсэлтээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талд дипломат шугамаар бичгээр мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дараа Хэлэлцээр хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг Иерусалим хотноо _____ он тооллоор 5756 оны _____ өдөртэй тохиож буй 1996 оны 3 дугаар сарын 12-ны өдөр монгол, иврит, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ӨМНӨӨС**

Гарын үсэг

**ИЗРАИЛЬ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ӨМНӨӨС**

Гарын үсэг